МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА,
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН

ГҮТГЭХ, ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ ТАРААХ ГЭМТ ХЭРЭГ: МОНГОЛ УЛСЫН БОЛОН ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Судалгааны төрөл:	**Харьцуулсан судалгаа**
Судалгааны код:	**СТ-25/207**
Хугацаа:	**2025.03.19**

Захиалагч:	Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн
Хянасан:	ПСХХ–ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга Д.Онолт ПСХХ–ийн Судалгааны хэлтсийн дарга Г.Гэсэр
Судалгаа удирдсан:	ПСХХ–ийн Судалгааны хэлтсийн зөвлөх Г.Билгээ
Судлаач:	ПСХХ–ийн Судалгааны хэлтсийн ахлах референт О.Нарантуяа

Улаанбаатар хот

2025 он

АГУУЛГА

УДИРТГАЛ 2
ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ 3
НЭГ. МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТОВЧ ТОЙМ 3
ХОЁР. ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ 5
2.1.ЭРҮҮГИЙН БОЛОН ИРГЭНИЙ ХУУЛИАР ЗОХИЦУУЛДАГ УЛСЫН ТУРШЛАГА 5
2.1.1.Холбооны Бүгд Найрамдах Герман Улс 5
2.1.2.Бүгд Найрамдах Польш Улс 6
2.1.3.Бүгд Найрамдах Унгар Улс 7
2.2.ЭРҮҮГИЙН БОЛОН САЛБАР, БУСАД ХУУЛИАР 8
ЗОХИЦУУЛДАГ УЛСЫН ТУРШЛАГА 8
2.2.1.Бүгд Найрамдах Болгар Улс 8
2.2.2.Бүгд Найрамдах Солонгос Улс 9
2.2.3.Шведийн Хаант Улс 11
2.3.БИЕ ДААСАН ХУУЛИАР ЗОХИЦУУЛДАГ УЛСЫН ТУРШЛАГА 13
2.3.1.Австралийн Холбооны Улс 13
2.3.2.Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс 15
СУДАЛГААНЫ ҮР ДҮН 20
АШИГЛАСАН МАТЕРИАЛ 22

Удиртгал

Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн захиалгаар “Гүтгэх, худал мэдээлэл тараах гэмт хэрэг: Монгол Улсын болон гадаадын зарим улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа”-г Улсын Их Хурлын Тамгын газрын дэргэдэх Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн (ПСХХ)-д гүйцэтгэв.

Судалгааны зорилго: Гүтгэх, доромжлох, худал мэдээлэл тараах гэмт хэргийг эрүү, иргэний болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэрхэн зохицуулж буйг судалж, тэдгээрийн ялгаа, онцлог болон эрх зүйн зохицуулалтын чиг хандлагыг харьцуулан шинжлэх.

Судалгааны хамрах хүрээ: Монгол Улсын болон гадаадын зарим орны эрүү болон иргэний хууль, хэвлэл мэдээллийн салбар болон бие даасан хуулиар гүтгэх, доромжлох, худал мэдээлэл тараахтай холбогдсон харилцааг хэрхэн зохицуулсан талаар харьцуулан судалсан болно.

Энэхүү харьцуулсан судалгаанд Freedom House, World Justice Project, Amnesty International зэрэг олон улсын байгууллагуудаас гаргадаг хүний эрх, эрх чөлөө, эрх зүйн засаглалын индекс зэргийг харгалзан Австралийн Холбооны Улс (Австрали Улс), Бүгд Найрамдах Болгар Улс (Болгар Улс), Бүгд Найрамдах Польш Улс (Польш Улс), Бүгд Найрамдах Солонгос Улс (Солонгос Улс), Бүгд Найрамдах Унгар Улс (Унгар Улс), Их Британи, Умард Ирландын нэгдсэн хаант улс (ИБУИНХУ), Холбооны Бүгд Найрамдах Герман улс (ХБНГУ), Шведийн Хаант Улс (Швед Улс)-ыг сонгон судалсан.

Судалгааны арга зүй: Судалгаанд сонгож авсан улс орнуудын эрүү, иргэний хууль, иргэний болон бусад холбогдох хууль тогтоомжийг харьцуулан судлах үүднээс харьцуулсан шинжилгээний арга, хууль зүйн баримт бичгийн судалгааны арга ашигласан болно.

Судалгааны ажлын бүтэц: Энэхүү судалгаа нь удиртгал, дэлгэрэнгүй хэсэг болон судалгааны үр дүнгээс бүрдэнэ. Судалгааны дэлгэрэнгүй хэсэг нь, эхний бүлэгт гүтгэх, худал мэдээлэл тараах гэмт хэргийн Монгол Улсын эрх зүйн зохицуулалтын талаар, хоёрдугаар бүлэгт гадаадын зарим улсын эрх зүйн зохицуулалтын талаар судалсан болно. Сүүлийн бүлэг нь нэгд, Эрүүгийн болон Иргэний хуулиар (ХБНГУ, Польш, Унгар), хоёрт, Эрүүгийн болон салбар, бусад хуулиар (Болгар, Солонгос, Швед), гуравт, бие даасан хуулиар (Австрали, ИБУИНХУ) зохицуулдаг талаар судалсан болно.

Түлхүүр үг: *Гүтгэх, гүтгэлэг, худал мэдээлэл, худал цуу яриа тараах, гүтгаах.*

Key words: *Defamation, insult, slander, libel, malicious gossip, desecration.*

ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТОВЧ ТОЙМ

Өнөөгийн байдлаар Монгол Улсад гүтгэх, худал мэдээлэл тараахтай холбоотой харилцааг Иргэний болон Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуулиар зохицуулж байна. Тодруулбал, Эрүүгийн хуулиар “худал мэдээлэл тараах” **гэмт хэргийг**, Зөрчлийн тухай хуулиар “гүтгэх” **зөрчлийг**, Иргэний хуулиар “иргэний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан” этгээдэд **гэм хорыг** арилгахтай холбоотой харилцааг тус тус зохицуулдаг.

А) ЭРҮҮГИЙН БОЛОН ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Манай улсад анх 1986 оны Эрүүгийн хуульд “гүтгэх” гэмт хэргийг тусгасан (Д.Оросоо, 2021) бөгөөд 2002 оны Эрүүгийн хуулийн 111 дүгээр зүйлд үргэлжлүүлэн зохицуулж байсан. Харин 2015 онд Эрүүгийн хуулийг[1] шинэчлэн батлахдаа “гүтгэх” гэмт хэргийг хасч, түүний оронд 13.14 дүгээр зүйлд “худал мэдээлэл тараах” гэмт хэргийг зохицуулах болсон.

Улсын Их Хурал (УИХ)-аас 2015 онд баталсан Эрүүгийн хуулиар гүтгэх, доромжлох үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй болж, 2017 онд баталсан Зөрчлийн тухай хуулиар[2] зохицуулах болсон. Зөрчлийн тухай хуулийн 6.21 дүгээр зүйлийн **“гүтгэх” зөрчил**д хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэсэн, эсхүл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараасан бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэж заасан.

УИХ-аас 2020 онд Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсны үр дүнд, Зөрчлийн тухай хуулиас “гүтгэх” зөрчлийг хасаж, Эрүүгийн хуульд “худал мэдээлэл тараах” нэртэйгээр гэмт хэрэгт тооцон оруулсан.

Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл **(худал мэдээлэл тараах)**-д хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол дараах ял шийтгэл оногдуулахаар заасан. Үүнд:

- 450-1300 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;
- 240-720 цаг хүртэл нийтэд тустай ажил хийлгэх;
- нэгээс гурван сарын хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах.

Мөн хуулийн 14.8 дугаар зүйл **(сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах)**-д сонгуульд оролцогч улс төрийн нам, намуудын эвсэл, нэр дэвшигчийн нэр хүндэд халдаж, илт худал мэдээлэл тараасан бол дараах ял шийтгэл оногдуулахаар заасан. Үүнд:

- 450-5400 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;
- 240-720 цаг хүртэл нийтэд тустай ажил хийлгэх;
- нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах.

Хэрэв энэ гэмт хэргийг төрийн албан хаагч, сонгуулийн хорооны албан тушаалтан, ажилтан үйлдсэн бол:

[1] Монгол (2015). Эрүүгийн хууль Хандах https://legalinfo.mn/mn/detail/11634 Хандсан огноо: 2025-03-14.
[2] Монгол (2017). Зөрчлийн тухай хууль Хандах https://legalinfo.mn/mn/detail/12695 Хандсан огноо: 2025-03-14.

- нэгээс гурван жил хүртэл хугацаагаар нийтийн албанд томилогдох эрх хасаж, 1350-10000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;
- зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах;
- зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан.

Б) ИРГЭНИЙ ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

2002 онд батлагдсан Иргэний хуулийн[3] 21 дүгээр зүйлийн 21.2-т “Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотолж чадахгүй бол эрх нь зөрчигдсөн этгээдийн шаардлагаар уг мэдээг тараасан хэлбэр, хэрэгсэл эсхүл өөр хэлбэр, хэрэгслээр няцаах үүрэг хүлээнэ” гэж заасан. Тус зүйлд заасан “гутаасан мэдээ” нь “худал” болон “үнэн” мэдээллийг давхар агуулдаг.

Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3-т бодит баримтыг бүрэн гүйцэд мэдээлээгүйгээс нэр төрийг гутаасан бол няцаах үүрэг хүлээхээр зохицуулсан. Иргэний хуулиар зохицуулж буй гутаасан мэдээ буюу бодит баримтыг бүрэн гүйцэд мэдээлээгүйгээс нэр төрийг гутаасан бол уг асуудал нь Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан “худал мэдээлэл тараах” гэмт хэрэгт тооцогдохгүй (Д.Оросоо, 2021, p. 48).

Тус хуулиар тогтоосон хувийн нууцад хамааралтай мэдээг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр тарааснаас гэм хор учирсан гэж үзвэл иргэн гэм хорыг арилгахыг шаардах эрхтэй. Иргэний нийгэмд эзлэх байр суурьтай холбогдуулан түүнийг сурталчлах зорилгоор болон сургалт, эрдэм шинжилгээний ажил, ажил хэргийн хүрээнд олон нийтийг хамарсан үйл ажиллагааны явцад уг этгээдийг дүрсэлсэн, эсхүл тухайн этгээд өөрийгөө дүрслүүлсний төлөө хөлс, шан харамж авсан бол түүний зөвшөөрөл шаардагдахгүй.

Нас барсан этгээдийн нэр, нэр төр, алдар хүндийг гутаасан, эсхүл түүний хувийн нууцтай холбоотой мэдээллийг Иргэний хуулийн 520 дугаар зүйлд заасан өвлөгчийн зөвшөөрөлгүйгээр олон нийтэд тараасан бол гэм хорыг арилгахыг шаардах эрхтэй бөгөөд харин учирсан гэм хорыг эдийн хэлбэрээр нөхөн төлүүлэхийг шаардах эрхгүй.

[3] Монгол (2002). Иргэний хууль Хандах https://legalinfo.mn/mn/detail/299 Хандсан огноо: 2025-03-14.

Хоёр. ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

2.1.ЭРҮҮГИЙН БОЛОН ИРГЭНИЙ ХУУЛИАР ЗОХИЦУУЛДАГ УЛСЫН ТУРШЛАГА

2.1.1.Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

А) ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (Герман Улс)-ын Эрүүгийн хуульд[4] гүтгэлгийг гэмт хэрэг гэж үздэг бөгөөд доромжлох, гүтгэхтэй холбоотой 4 төрлийн гэмт хэргийг зохицуулсан.

Эрүүгийн хуулийн 185 дугаар зүйл (**доромжлох-**“insult”)-д доромжлох үйлдэл үйлдсэн этгээдэд нэг жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл торгох ял оногдуулахаар заасан. Хэрэв доромжлолыг олон нийтийн өмнө, хуралдаан дээр, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан эсхүл хүч хэрэглэн үйлдсэн бол хоёр жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл торгох ял оногдуулна.

Мөн 186 дугаар зүйл (**худал цуу яриа тараах**-“malicious gossip”)-д хэн нэгний талаар түүнийг гутаах, олон нийтийн үнэлэмжийг нь бууруулахуйц мэдээлэл тараах буюу түгээсэн боловч уг мэдээлэл нь үнэн болох нь нотлогдоогүй бол тухайн этгээдэд нэг жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл торгох ял оногдуулна. Хэрэв уг гэмт хэргийг олон нийтийн өмнө, хуралдаан дээр эсхүл, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан үйлдсэн бол хоёр жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл торгох ял оногдуулахаар заасан.

Эрүүгийн хуулийн 187, 188 дугаар зүйлд гүтгэхтэй холбоотой харилцааг зохицуулсан. Хуулийн 187 дугаар зүйл (**гүтгэх**–“defamation”)-д хэрэв хүн бодит байдалтай нийцэхгүй мэдээлэл тараах буюу түгээхдээ түүний худал гэдгийг мэдэж байсан, уг мэдээлэл нь тухайн хүний нэр төрийг гутаах, олон нийтийн үнэлэмжийг нь бууруулах, эсхүл зээлийн чадварт нь эрсдэл учруулахуйц байвал тухайн этгээд хоёр жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл торгох ял оногдуулна. Хэрэв уг үйлдлийг олон нийтийн өмнө, хуралдаан дээр, эсхүл хэвлэл мэдээллийн хэрэгслээр (§11.3) дамжуулан үйлдсэн бол таван жил хүртэл хорих ял, эсхүл торгох ял оногдуулна.

Тус хуулийн 188 дугаар зүйл (insult, maicious gossip and defamation directed at person in political life)-д улс төрийн амьдралд оролцож буй хүмүүст чиглэсэн доромжлол, худал цуу яриа тараах, гүтгэхтэй холбоотой харилцааг зохицуулжээ. Тухайлбал, хэрэв **доромжлох** гэмт хэргийг (§185) олон нийтийн өмнө, хуралдаан, эсхүл хэвлэл мэдээллийн хэрэгслээр (§11.3) дамжуулан улс төрийн амьдралд оролцож буй хүн рүү, тухайн хүний албан тушаалтай нь холбож үйлдсэн бол, мөн энэ үйлдэл тухайн хүний олон нийтийн үйл ажиллагааг мэдэгдэхүйц хүндрүүлэхээр байвал гурван жил хүртэл хугацаагаар хорих ял, эсхүл торгох ял оногдуулна. Улс төрийн амьдралын энэ ойлголт нь орон нутгийн түвшинд ч хамаарна. Дээрхтэй ижил нөхцөлд **худал мэдээлэл тараасан** (§186) тохиолдолд гурван сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулна. Харин **гүтгэсэн** (§187) бол зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар тус тус заасан.

Б) ИРГЭНИЙ ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

[4] Герман (1998) [2021]. German Criminal Code
Хандах https://www.gesetze-im-internet.de/englisch_stgb/englisch_stgb.html Хандсан огноо:2025-02-20.

Герман Улсын Иргэний хуулийн[5] 823 дугаар зүйл (**хохирол барагдуулах үүрэг-**“liability in damages”)-д зааснаар хэрэв хүн бусдын амь нас, бие махбод, эрүүл мэнд, эрх чөлөө, өмч хөрөнгө болон бусад хууль ёсны эрхийг санаатай, эсхүл хайхрамжгүйгээр зөрчсөн бол хохирол учирсан этгээдэд нөхөн төлбөр төлөх үүрэгтэй. Хэрэв бусдын эрхийг хамгаалах зорилготой хууль зөрчсөн бол тухайн зөрчлөөс үүссэн хохирлыг барагдуулах үүрэгтэй.

Хуулийн 824 дүгээр зүйл (**зээлийн эрсдэлд оруулах**–“endangering credit”)-д зааснаар хэрэв хүн бусдын санхүүгийн нэр хүндэд халдаж болзошгүй буюу түүний амжиргаа, ажил мэргэжлийн хөгжилд саад учруулж болзошгүй худал мэдээлэл тараасан бол түүнээс үүдсэн хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй. Энэ нь тухайн мэдээлэл худал гэдгийг мэдээгүй байсан ч, мэдэх ёстой байсан аль ч тохиолдолд хамаарна.

2.1.2.Бүгд Найрамдах Польш Улс

А) ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Бүгд Найрамдах Польш Улс (Польш Улс)-ын хувьд гүтгэхтэй холбоотой харилцаанд Европын Холбооны удирдамж, Эрүүгийн болон Иргэний хуулийг дагаж мөрддөг.

Эрүүгийн хуульд заасан гүтгэлгийн гэмт хэргийн зохицуулалт нь хувь хүн, аж ахуй нэгжийг олон нийтийн нэр хүндэд халдсан, тэдний мэргэжил, үйл ажиллагаанд итгэх итгэлийг бууруулсан худал мэдээллээс хамгаалах зорилготой.

Эрүүгийн хуулийн[6] 212 дугаар зүйл (**гүтгэх**)-д хэрэв хүн өөр нэгэн хувь хүн, бүлэг хүмүүс, байгууллага, хуулийн этгээд биш боловч тодорхой үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын талаар олон нийтийн өмнө нэр хүндийг нь гутаах, эсхүл тухайн байгууллага, хувь хүний албан тушаал, мэргэжил, үйл ажиллагаанд шаардлагатай итгэлийг алдагдуулахуйц үйлдэл, шинж чанар оноож гүтгэвэл торгох, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулна. Хэрэв энэхүү үйлдлийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан үйлдсэн бол торгох, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулна. Дээрх гэмт хэргийг үйлдсэн тохиолдолд шүүхээс нөхөн төлбөр төлөх нэмэгдэл ял ногдуулж болох бөгөөд гүтгэх гэмт хэргийн хувьд зөвхөн хохирогч нэхэмжлэл гаргасан тохиолдолд эрүүгийн хариуцлагад татна.

Эрүүгийн хуулийн 216 дугаар зүйл (**доромжлох**-“insult”)-д хэрэв хүн бусдыг түүний нүүрэн дээр, түүний байхгүй үед олон нийтийн өмнө эсхүл тухайн доромжлолыг хохирогчид хүргэх зорилгоор доромжилсан бол торгууль, эсхүл хорих ял оногдуулах бөгөөд олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглан бусдыг доромжлох гэмт хэрэг үйлдсэн бол торгох, эсхүл, нэг жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар зохицуулсан. Мөн шүүхээс нэмэлт нөхөн төлбөр оногдуулах ял ногдуулж болно. Хэрэв доромжлолыг өдөөсөн үйлдэл нь өөрийнх нь турхиралттай холбоотой байсан, эсхүл доромжлогдсон хүн өөрөө бие махбодын халдлага үйлдсэн эсхүл хариу доромжилсон бол шүүх тухайн этгээдэд ял оногдуулахаас татгалзаж болно.

Б) ИРГЭНИЙ ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

[5] Герман (2021). Civil code Хандах https://www.gesetze-im-internet.de/englisch_bgb/ Хандсан огноо: 2025-03-18.
[6] Польш (1997) [2010]. The Penal Code Хандах https://legislationline.org/sites/default/files/documents/6a/Poland_CC_1997_en.pdf Хандсан огноо: 2025-02-20.

Тус улсад хүний нэр төр, хувийн нууцыг Иргэний хуулийн[7] 23 ба 24 дүгээр зүйлд заасны дагуу эрүүл мэнд, эрх чөлөө, нэр хүнд, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх зэрэг хүний хувийн халдашгүй эрх, ашиг сонирхлыг хамгаалдаг. Иргэний хуулийн 24 дүгээр зүйлд зааснаар хэрэв нэгэн этгээдийн хувийн эрх ашиг нь өөр хүний үйлдлээс болж аюулд өртсөн бол тухайн үйлдэл хууль бус биш л бол тэрхүү үйлдлийг зогсоохыг шаардах эрхтэй. Хэрэв аль хэдийн зөрчигдсөн бол хохирогч нь зөрчил үйлдсэн этгээдээс зөрчлийн үр дагаврыг арилгах шаардлагатай үйлдэл хийхийг шаардах эрхтэй. Үүнд, зохих хэлбэр агуулга бүхий уучлал хүсэх, мэдэгдэл хийх, мөн Иргэний хуульд заасан нөхцөлийн дагуу нөхөн төлбөр шаардах, эсхүл тодорхой нийгмийн зорилготой байгууллагад мөнгөн төлбөр төлүүлэхийг шаардаж болно.

Иргэний хуулийн 448 дугаар зүйлд зааснаар нэр төр нь зөрчигдсөн эсэхийг шүүх тодорхойлохдоо нөхөн төлбөрийг хохирогчид өөрт нь, эсхүл хохирогчийн сонгосон нийгмийн зорилготой байгууллагад олгож болох, мөн нөхөн төлбөр оногдуулахгүй байх шийдвэрүүдийг гаргаж болно. Нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо хэргийн нөхцөл байдал, шүүгдэгчийн гэм буруугийн байдал, зөрчигдсөн хувийн эрх ашгийн байдал зэргийг харгалзан үзнэ. Иргэний эрх зүйн зохицуулалтаар нэхэмжлэгч нь мэдүүлгийн худал, нийтэлсэн мэдээлэл нь түүний нэр хүндэд халдсан, халдах боломжтойг нотлох ёстой.

2.1.3.Бүгд Найрамдах Унгар Улс

А) ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Бүгд Найрамдах Унгар Улс (Унгар Улс)-ын Эрүүгийн хуульд[8] гүтгэх, доромжлох, гутаах гэсэн 3 гэмт хэргийг зохицуулдаг.

Тус хуулийн 226 дугаар зүйлд **гүтгэх** (defamation) гэмт хэргийн талаар зохицуулсан. Тухайлбал, хэрэв хүн бичгээр, эсхүл амаар бусдын нэр төр, нэр хүндэд халдсан мэдээлэл нийтлэх, тараах, эсхүл ийм утга бүхий үг хэллэг ашигласан бол нэг жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулна. Хэрэв дараах хүндрүүлэх нөхцөл байдалтай үйлдэгдсэн бол хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулна. Үүнд:

а) санаатайгаар болон өш хонзон санаж гүтгэсэн бол;

б) олон нийтэд зориулсан хэвлэл мэдээллийн хэрэгслээр тараасан бол;

с) хохирогчид ноцтой хохирол учруулсан бол.

Эрүүгийн хуулийн 227 дугаар зүйлд **амаар гүтгэх** (slander) гэмт хэргийг зохицуулсан. Хэрэв хүн Эрүүгийн хуулийн 226 дугаар зүйлд заасан гүтгэлгээс гадна дараах байдлаар худал мэдээлэл тараасан бол нэг жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулна. Үүнд:

- хэн нэгний мэргэжлийн үйл ажиллагаа, албан тушаал, олон нийтийн ажилтай нь холбогдуулан нэр хүндийг нь гутаах зорилготой байсан бол;
- олон нийтийн өмнө (нийтэд нээлттэй байдлаар) тараасан бол.

Хэрэв бусдыг гүтгэхийн тулд бие махбодын халдлага (physical assault) үйлдсэн бол нэг жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулна.

Эрүүгийн хуулийн 228 дугаар зүйлд **гутаах** (desecration) гэмт хэргийн талаар зохицуулсан. Тухайлбал, хэрэв хүн 226 дугаар зүйл (гүтгэх) эсхүл 227 дугаар зүйл (амаар

[7] Поьш (1964). Civil code. Хандах https://faolex.fao.org/docs/pdf/pol216860Polish.pdf Хандсан огноо: 2025.03.10
[8] Унгар (2012). Criminal Code.
Хандах https://thb.kormany.hu/download/a/46/11000/Btk_EN.pdf Хандсан огноо: 2025-02-20.

гүтгэх)-д заасан арга хэлбэрээр гутаасан бол мөн адил хэмжээний хорих ял оногдуулах бөгөөд хөнгөн гэмт хэрэг (misdemeanor) гэж үзнэ.

Эрүүгийн хуулийн 226-228 дугаар зүйлд заасан гэмт хэрэгт холбогдох мэдээлэл нь үнэн болох нь нотлогдсон бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх бөгөөд үнэн зөв мэдээлэл өгсөн тохиолдолд хуулийн дагуу хамгаалах арга хэмжээ авч болно гэж ерөнхий байдлаар тусгасан байна.

Б) ИРГЭНИЙ ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Иргэний хуулийн 2:45 дугаар зүйл[9] (Нэр төр, алдар хүндийг хамгаалах-)-д **гүтгэх** (defamation) гэж бусдын талаар үзэл бодлоо илэрхийлэхдээ нийгэмд тухайн хүний талаар сөрөг ойлголт бий болгохуйц хэт доромжилсон хэлбэрээр илэрхийлэхийг хэлнэ гэж, мөн **нэр хүндэд халдах** (violation of good reputation) гэж худал мэдээлэл тараах эсхүл буруу мэдээлэх замаар бусдыг доромжлох, үнэн мэдээллийг зориудаар гуйвуулж буруу ойлголт төрүүлэхийг хэлнэ гэж тус тус тодорхойлсон.

Иргэний хуулийн 2:43 дугаар зүйл (Хувь хүний онцгой эрхүүд-“Specific personality rights”)-д хувь хүний эрхийг зөрчсөн үйлдэлд дараах үйлдлүүдийг хамааруулсан. Үүнд:

а) амь нас, бие махбод, эрүүл мэндэд хор хохирол учруулах;
б) хувийн эрх чөлөө, нууцлал, орон байрны халдашгүй байдалд халдах;
в) хувь хүнийг ялгаварлан гадуурхах;
г) гүтгэх буюу нэр төр, алдар хүндийг гутаах;
д) хувийн нууцыг задруулах, хувийн мэдээллийг хамгаалах эрхийг зөрчих;
е) хүний нэрийг зөвшөөрөлгүйгээр ашиглах;
ё) хүний зураг, дүрс бичлэг, дуу хоолойг хамгаалах эрхийг зөрчих.

Иргэний хуулийн 2:52 дугаар зүйл (Нөхөн төлбөр-restitution)-д хувийн асуудалтай холбоотой эрх нь зөрчигдсөн аливаа этгээд материаллаг бус зөрчлийн нөхөн төлбөр авах эрхтэй. Шүүх зөрчлийн нөхцөл байдал, давтамж, хариуцлагын арга хэмжээ, зөрчлийн хохирогч болон түүний хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөө зэргийг харгалзан нөхөн төлбөрийн хэмжээг тогтооно.

2.2.ЭРҮҮГИЙН БОЛОН САЛБАР, БУСАД ХУУЛИАР ЗОХИЦУУЛДАГ УЛСЫН ТУРШЛАГА

2.2.1.Бүгд Найрамдах Болгар Улс

А) ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Бүгд Найрамдах Болгар Улс (Болгар Улс)-ын Эрүүгийн хуульд[10] доромжлох, гүтгэх болон хууль бусаар олж авсан мэдээлэл тараах гэмт хэргийг зохицуулсан. Эрүүгийн хуулийн 146 дугаар зүйл (**доромжлох**-“insult”)-д бусдын нэр төр, алдар хүндийг гутаах үг хэлэх эсхүл үйлдэл гаргасан (тухайн хүний нүүрэн дээр нь) бол 1000-3000 хүртлэх левийн торгууль, олон нийтийн өмнө эсхүл хэвлэмэл хэлбэрээр үйлдсэн бол 3000-10,000 хүртэл левийн торгууль оногдуулна. Хэрэв доромжлогдсон хүн нь шууд хариу доромжилсон бол шүүх хоёр талыг хариуцлагаас чөлөөлж болно. Хэрэв дараах хүндрүүлэх нөхцөл байдал илэрсэн бол 500-10,000 хүртлэх левийн торгууль, эсхүл олон нийтийн өмнө зэмлэх ял шийтгэл оногдуулна. Үүнд:

[9] Унгар (2013). Civil Code. Хандах https://faolex.fao.org/docs/pdf/hun209514.pdf Хандсан огноо: 2025-03-10.
[10] International Press Institute (Media Laws database) Хандах http://legaldb.freemedia.at/legal-database/bulgaria/?target=criminal-defamation Хандсан огноо: 2025-02-27.

- олон нийтийн өмнө үйлдэгдсэн бол;
- хэвлэл мэдээллийн хэрэгсэл эсхүл бусад аргаар тараагдсан бол;
- албан тушаалтан эсхүл олон нийтийн төлөөлөгч үүргээ гүйцэтгэх явцдаа үйлдсэн бол;
- арьс өнгө, гадаад улсад дайсагнах үзлээр үйлдэгдсэн бол.

Эрүүгийн хуулийн 147 дугаар зүйл (**Гүтгэх**-“Slander”)-д бусдын нэр төрийг гутаахуйц худал мэдээлэл тараасан, эсхүл түүнийг гэмт хэрэг үйлдсэн гэж буруутгасан бол 3000-7000 хүртлэх левийн торгууль, олон нийтийн өмнө, эсхүл хэвлэмэл хэлбэрээр үйлдсэн бол 5,000-15,000 хүртэл левийн торууль оногдуулна. Хэрэв тараасан мэдээлэл нь үнэн зөв болохыг нотолсон бол хариуцлагаас чөлөөлнө. Дээр дурдсан хүндрүүлэх нөхцөл байдал илэрсэн буюу гүтгэлэг нь ноцтой үр дагавар дагуулсан бол 1000-15,000 хүртлэх левийн торгууль, эсхүл олон нийтийн өмнө зэмлэх ял оногдуулна.

Эрүүгийн хуулийн 148а дугаар зүйл (**Хууль бусаар олж авсан мэдээлэл тараах**)-д бусдын талаар мэдээлэл, баримт, мэдэгдлийг аман хэлбэрээр, хэвлэл мэдээллээр, эсхүл бусад аргаар тараасан бөгөөд уг мэдээлэл нь Дотоод хэргийн яамны архиваас хууль бусаар олж авсан бол 5000-20,000 хүртлэх левийн торгох ял оногдуулна.

Б) САЛБАР, БУСАД ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Үүрэг, гэрээний тухай хууль (Law of obligations and contracts[11])-ийн 45 дугаар зүйл (Хохирлыг нөхөн төлөх үүрэг)-д хувь хүн өөрийн буруутай үйлдлээс болж бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй гэж заасан. Бүх төрлийн гэм хор учирсан тохиолдолд тухайн этгээд буруутай гэж урьдчилан таамаглах бөгөөд эсрэгээр нотлогдох хүртэл энэ зарчим хүчинтэй байна. Болгар Улсын хууль тогтоомжид нэр төрд халдсаны улмаас төлөх мөнгөн бус хохирлын дээд хязгаар тогтоогдоогүй бөгөөд 52 дугаар зүйлд гэм хорын нөхөн төлбөрийг шүүхийн үзэмжээр, шударга ёсны зарчимд үндэслэн тогтооно гэж заасан.

Тус хуулийн 16.1 дүгээр зүйлд хэвлэл мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч нь хүний хувийн амьдралтай холбоотой мэдээлэл бүхий контент үүсгэх, түгээхдээ тухайн хүний зөвшөөрлийг авах ёстой. Гэхдээ тухайн мэдээлэл нь нийтийн ашиг сонирхол хөндөгдсөн тохиолдолд, төрийн байгууллагын бүрэн эрхээ хэрэгжүүлж буй иргэн болон олон нийтэд нөлөө бүхий иргэдийн хувийн мэдээллийг хэвлэл мэдээллийн байгууллага олон нийтэд түгээж болно гэж заасан. Хуулийн 17(4)-д хэвлэл мэдээллийн үйлчилгээ үзүүлэгчид албан ёсны сувгаар хүлээн авсан, албан ёсны баримт бичгийг иш татсан, олон нийтийн мэдэгдлийг үнэн зөв хуулбарласан мэдээллийн төлөө хариуцлага хүлээхгүй гэж тус тус заасан.

2.2.2.Бүгд Найрамдах Солонгос Улс

А) ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Бүгд Найрамдах Солонгос Улс (Солонгос Улс)-ын Эрүүгийн хуулийн[12] 307 дугаар зүйл (**Гүтгэх**-“Defamation”)-д бусдыг худал баримтаар гүтгэсэн бол хоёр жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл таван сая хүртэл вонын торгууль оногдуулна. Хэрэв бусдыг олон нийтэд худал мэдээлэл тараан гүтгэсэн бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял, арван жил хүртэл

[11] Болгар (1950). Law of obligations and contracts. Хандах https://www.bulgaria-law-of-obligations.bg/law.html Хандсан огноо: 2025-03-13.
[12] Солонгос (1953). Criminal Act. Хандах https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=28627&lang=EN Хандсан огноо:2025-03-13.

хугацаагаар эрх хасах, эсхүл 10 сая хүртэл вонын торгууль оногдуулна. Харин 308 дугаар зүйл (**нас барсан хүнийг гүтгэх**-“Defamation of dead person”)-д хэрэв нас барсан хүний нэр төрийг олны өмнө гүтгэсэн бол хоёр жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл таван сая хүртэл вонын торгууль оногдуулна.

Тус хуулийн 309 дүгээр зүйл (**нийтлэлээр гүтгэх**-“defamation through printed materials”)-д олон нийтийн өмнө үнэн гэж үзсэн мэдээллээр бусдын нэр төрийг гутаасан гэмт хэргийг сонин, сэтгүүл, радио, бусад хэвлэлээр бусдын нэр төрийг гутаан доромжлох зорилгоор үйлдсэн бол гурван жил хүртэл хугацаагаар хорих ял, эсхүл долоон сая хүртэл вонын торгууль оногдуулахаар заасан. Харин хэвлэл мэдээллийн хэрэгслээр гүтгэсэн бол долоон жил хүртэл хугацаагаар хорих, арван жил хүртэл хугацаагаар эрх хасах, эсхүл 15 сая хүртэл вонын торгууль оногдуулна.

Эрүүгийн хуулийн 311 дүгээр зүйл (**доромжлох**-“insult”)-д бусдыг олны өмнө доромжилсон бол нэг жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл хоёр сая хүртэл вонын торгууль оногдуулна.

Б) САЛБАР, БУСАД ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Хэвлэлийн арбитр, хохирол нөхөн төлөх тухай хууль[13] (Act on press arbitration and damage remedies) нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан бусдын нэр хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн, мөн энэ асуудлаар маргаан үүссэн тохиолдолд маргааныг шийдвэрлэх, эвлэрүүлэн зуучлах, арбитрын үйл ажиллагаа явуулахтай холбоотой харилцааг зохицуулдаг.

Тус хуулийн 31 дүгээр зүйл (Special Provisions in Cases of Defamation)-д шүүхээс хэвлэл мэдээллийн хэрэгслээр бусдын нэр төрийг гутаасан этгээдэд хохирогчид учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, эсхүл залруулсан мэдэгдэл нийтлэх зэрэг нэр төрийг нь сэргээх арга хэмжээг дангаар, эсхүл давхардуулан ногдуулж болно гэж заасан.

Мэдээлэл, харилцааны сүлжээний ашиглалт, мэдээллийн хамгаалалтыг дэмжих тухай хууль (Act on promotion of information and communications network utilization and information protection)[14]-ийн 44 дүгээр зүйлд мэдээлэл, харилцаа холбооны сүлжээнд хэрэглэгч нь бусдын эрхийг зөрчсөн, түүний дотор хувийн нууцад халдах, гүтгэх зэрэг мэдээллийг сүлжээгээр тараахыг хориглосон. Хэрэв хэрэглэгчийн нийтэлсэн, тараасан мэдээлэл нь хувийн нууцад халдсан, гүтгэсэн, эрхийг нь зөрчсөн гэж үзэж байгаа этгээд хуулийн 44-10-т заасан гүтгэлгийн маргаан зохицуулах хороонд иргэний нэхэмжлэл гаргах эрхтэй.

Тус хуулийн 44-10 дугаар зүйлд гүтгэлгийн маргааныг хянан шийдвэрлэх хорооны талаар зохицуулсан. Гүтгэлгийн маргаан хянан шийдвэрлэх хороо нь мэдээлэл, харилцаа холбооны сүлжээгээр түгээж буй мэдээллийн дунд бусдын эрхийг зөрчсөн, тухайлбал, хувийн нууцад халдах, гүтгэх зэрэгтэй холбоотой маргааныг шийдвэрлэх үүрэгтэй 5 гишүүнээс бүрддэнэ. Тус хороо нь эвлэрүүлэн зуучлах журмыг баримтлан ажиллана.

Тус хуулийн 70 дугаар зүйлд мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ ашиглан доромжилсон бол шүүхээс дараах ял шийтгэл оногдуулахаар заасан. Үүнд:

---

[13] Солонгос (2005). Act on press arbitration and damage remedies. Хандах https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=24492&type=part&key=17 Хандсан огноо:2025-03-10.

[14] Солонгос (1986). Act on promotion of information and communications network utilization and information protection. Хандах https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=38422&lang=ENG Хандсан огноо: 2025-03-15.

- мэдээлэл, харилцаа холбооны сүлжээгээр бусдын нэр төрийг гутаан доромжлох зорилгоор баримтыг олон нийтэд дэлгэн гүтгэсэн бол 3 жил хүртэл хугацаагаар хорих эсхүл 30 сая хүртэл воноор торгоно;
- тухайн хүнийг гүтгэх зорилгоор мэдээлэл, харилцаа холбооны сүлжээгээр худал баримтыг нийтэд дэлгэн гүтгэсэн бол 7 жил хүртэл хугацаагаар хорих эсхүл 10 хүртэл жилийн хугацаагаар мэргэжлээрээ ажиллах эрхийг нь түдгэлзүүлнэ, эсхүл 50 сая хүртэл воноор торгоно.

Иргэний хуулийн[15] 750 дугаар зүйлд хууль бус үйлдлээр бусдад санаатай болон болгоомжгүй байдлаар хохирол учруулсан этгээд хохирлыг нөхөн төлөхийг үүрэг болгосон бол 764 дүгээр зүйлд бусдын нэр төрийг гутаасан этгээдэд шүүхээс учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, нэр төрийг нь сэргээх зэрэг зохих арга хэмжээ авахаар зохицуулсан байна.

Хэрэв хэвлэл мэдээллийн байгууллага хууль зөрчсөн бол хохирогч тал нь учирсан эдийн засаг, сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэхээр нэхэмжлэл гаргаж болох бөгөөд үүнийгээ нотлох шаардлагатай. Хэвлэлийн арбитр, хохирол нөхөн төлүүлэх тухай хуулиас ялгаатай нь эдгээр нэхэмжлэлийг бие даасан сэтгүүлч, сурвалжлагчийн эсрэг гаргаж болно.

2.2.3.Шведийн Хаант Улс

А) ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Шведийн Хаант Улс (Швед Улс)-ын Эрүүгийн хуулийн 5 дугаар бүлэгт гүтгэх, доромжлох гэмт хэргийг зохицуулсан[16].

Эрүүгийн хуулийн 5 дугаар бүлгийн 1 дүгээр зүйл (**гүтгэх** – “defamation”)-д бусдыг гэмт хэрэгтэн гэж харуулах, эсхүл тэдний амьдралын хэв маягийг шүүмжлэх, эсхүл бусдыг үл хүндлэхэд хүргэхүйц мэдээлэл тараавал тухайн хүнийг гүтгэсэн гэж үзэж торгох ял оногдуулна. Гэхдээ хэрэв тухайн хүн мэдээлэл өгөх үүрэгтэй байсан, эсхүл нөхцөл байдлыг харгалзан үзэхэд мэдээлэл өгөх нь зохистой байсан бөгөөд мэдээлэл үнэн гэдгийг нотолсон, эсхүл үндэслэл бүхий шалтгаантай байсан бол хариуцлага оногдуулахгүй.

Тус бүлгийн 2 дугаар зүйл (**хүнд хэлбэрээр гүтгэх-**“gross defamation”)-д гүтгэх үйлдэл нь онц ноцтой, эсхүл хүнд хэлбэрийн гүтгэлэгт тооцож торгууль, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулна. Гүтгэлгийн хүндрүүлэх нөхцөл байдалд дараах хүчин зүйлс хамаарна. Үүнд:

- мэдээллийн агуулга;
- мэдээллийг түгээх арга хэлбэр, хүрээ;
- хохирогчид учруулсан ноцтой хор уршиг.

Тус бүлгийн 3 дугаар зүйлд бусдыг буруутгах, гутаах эсхүл доромжлох үг, үйлдэл гаргаж, энэ нь тухайн хүний өөрийгөө хүндлэх мэдрэмж, нэр төрийг гутаахуйц байвал доромжлол үйлдсэн гэж үзэж торгох ял оногдуулна. Хэрэв доромжлол нь онц ноцтой гэж үзвэл торгууль, эсхүл зургаан сар хүртэл хугацаагаар хорих ял оногдуулна. Харин нас барсан хүний талаар гүтгэлэг үйлдсэн (§4) бол ар гэрийнхэнд учруулсан сэтгэл санааны хохирол болон нас барсан хүний нэр төрийг доромжилсон гэж үзвэл энэ бүлгийн 1, 2 дугаар зүйлд заасан хариуцлага оногдуулна.

---

[15] Солонгос (2022). Civil act. Хандах https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=61788&lang=ENG Хандсан огноо:2025-03-11.
[16] Швед (1962). The Swedish Criminal Code. Хандах https://www.government.se/contentassets/7a2dcae0787e465e9a2431554b5eab03/the-swedish-criminal-code.pdf Хандсан огноо:2025-03-13.

Тус бүлгийн 5 дугаар зүйлд гүтгэх, доромжлох гэмт хэргийг зөвхөн хохирогч өөрөө шүүхэд нэхэмжлэл гаргаж шалгуулна. Гэхдээ дараах тохиолдолд прокурор өөрөө хэрэг үүсгэж болно. Үүнд:

- хохирогч 18 насанд хүрээгүй бол;
- нийгмийн нийтлэг эрх ашгийг хамгаалах шаардлагатай гэж үзсэн бол (жишээ нь, албан тушаалтанг гүтгэсэн, эсхүл арьс өнгө, үндэс угсаа, шашин шүтлэг, хүйсийн баримжаа зэргээр ялгаварлан доромжилсон тохиолдолд);
- нас барсан хүнийг гүтгэсэн тохиолдолд хамгийн ойрын гэр бүлийн гишүүн (эхнэр, нөхөр, хүүхэд, эцэг эх, ах, эгч, дүү) шүүхэд хандах бөгөөд хэрэв энэ нь нийтийн ашиг сонирхолд нийцнэ гэж үзсэн бол.

Хэрэв 1-3 дугаар зүйлд заасан гэмт хэрэг нь гадаад улсын төлөөлөгчийг гутаасан бол тухайн хэрэгт Засгийн газрын зөвшөөрөлтэйгөөр прокурор хэрэг үүсгэж болно.

Б) ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Тус улсын хувьд, гүтгэх, доромжлох гэмт хэргийг Эрүүгийн хуулиас гадна Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль болон Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний тухай хуулиар тус тус зохицуулдаг.

Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль (Freedom of the Press Act[17])-ийн 7 дугаар бүлэгт хэвлэлийн эрх чөлөө, мэдээлэл дамжуулах эрх чөлөө, мэдээлэл олж авах эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн талаар зохицуулсан. Тус бүлгийн 1 дүгээр зүйлд хэвлэлийн эрх чөлөөний зорилго нь үзэл бодлоо чөлөөтэй солилцох, үнэн бодит мэдээлэл авах боломжийг хангах, урлагийн бүтээл туурвих эрх чөлөөг дэмжих явдал юм. Тус бүлгийн 2-20 дугаар зүйлүүдэд заасан гэмт хэргүүдийг хэвлэлийн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг гэж үзэх бөгөөд эдгээр гэмт хэргийг хэвлэлээр дамжуулан үйлдсэн бол хуульд заасны дагуу хариуцлага хүлээнэ. Хэвлэлийн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг үйлдсэн эсэхийг шүүх шийдвэрлэнэ.

Тус бүлгийн 3 дугаар зүйл (**гүтгэх**–“defamation”)-д бусдыг гэмт хэрэгтэн гэж харуулах, амьдралын хэв маягийг нь шүүмжлэх, эсхүл түүнийг бусдын жигшил зэвүүцэл төрүүлэхүйц мэдээлэл тараасан бол хэвлэлийн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг гэж үзнэ. Нас барсан хүнийг гүтгэсэн тохиолдолд хэрэв энэ үйлдэл нь талийгаачийн ойр дотны хүнд сэтгэл санааны хохирол учруулсан, эсхүл булш, шарилын ариун байдлыг зөрчсөн гэж үзвэл хариуцлага хүлээнэ. Гэхдээ тухайн мэдээллийг өгөх нь зөв зүйтэй байсан, мэдээлэл нь үнэн болохыг нотолсон, эсхүл үндэслэл бүхий шалтгаантай байсан бол хариуцлагаас чөлөөлнө.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний тухай хууль (Fundamental Law on Freedom of Expression[18])-ийн 5 дугаар бүлэгт үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл дамжуулах, мэдээлэл олж авах эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн талаар зохицуулсан. Тус бүлгийн 1 дүгээр зүйлд Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн 7 дугаар бүлгийн 2-20 дугаар зүйлүүдэд заасан гэмт хэргийг программ эсхүл техникийн бичлэг ашиглан үйлдсэн бол үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг гэж үзнэ. Гэхдээ энэ хуульд заасны дагуу шийтгэл оногдуулах үндэслэлтэй байх шаардлагатай бөгөөд тэдгээр гэмт хэргийг төрийн албанд ажиллаж байхдаа, эсхүл түүнтэй адилтгах бусад нөхцөл байдлын улмаас тухайн мэдээлэлтэй танилцсан этгээд, нууц хадгалах үүрэг бүхий этгээд, үндэсний аюулгүй

[17] Швед (1949). The Freedom of the Press Act. Хандах https://www.riksdagen.se/globalassets/05.-sa-fungerar-riksdagen/demokrati/the-freedom-of-the-press-act-2023-eng.pdf Хандсан огноо:2025-03-11.
[18] Швед (1991). Fundamental Law on Freedom of Expression. Хандах https://www.riksdagen.se/globalassets/05.-sa-fungerar-riksdagen/demokrati/the-fundamental-law-on-freedom-of-expression-2023-eng.pdf Хандсан огноо:2025-03-10.

байдлын эсрэг гэмт хэрэг болох мэдээллийг тус тус санаатайгаар нийтэлсэн бол хэвлэлийн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг гэж үзэхээр заасан.

Тус бүлгийн 3 дугаар зүйлд хэрэв зар сурталчилгаа эсхүл бусад мэдээллийн агуулгаас нь харахад ямар нэгэн хариуцлага хүлээх үндэслэлтэй гэмт хэрэг үйлдэгдсэн нь шууд тодорхой бус бол, үүнийг үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг гэж үзэхгүй. Харин тухайн мэдээлэл далд утга агуулж хууль зөрчсөн бол хуульд заасан хариуцлага оногдуулна. Энэхүү зохицуулалт нь олон нийтээс нууц код эсхүл шифрээр дамжуулсан мэдээлэлд мөн хамаарна.

Дээр дурдсан үйлдлүүдэд ял шийтгэл оногдуулахдаа нийтлэгдсэн мэдээлэл өөрчлөгдсөн эсэх, хэрэв өөрчлөгдсөн бол уг мэдээллийг зохих ёсоор дахин нийтэлсэн эсэхийг харгалзан үзнэ.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний тухай хуулийн 5 дугаар бүлгийн 7 дугаар зүйлд хэрэв шүүхээс яллагдагчийг гүтгэх, доромжлох эсхүл, бүдүүлэг зан авир гаргасан гэж буруутгавал, хохирогчийн хүсэлтээр тухайн шийдвэрийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл дээр (програм эсхүл дамжуулалтын суваг) бүрэн эсхүл хэсэгчлэн нийтлүүлэх боломжтой. Шүүхээс шийдвэрийг хураангуйлсан хэлбэрээр нийтлэх эрхийг ч мөн өгч болно.

2.3.БИЕ ДААСАН ХУУЛИАР ЗОХИЦУУЛДАГ УЛСЫН ТУРШЛАГА

2.3.1.Австралийн Холбооны Улс

ГҮТГЭЛГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Австралийн Холбооны Улс (Австрали Улс)-ын Гүтгэлгийн тухай хууль19 нь 2005 онд батлагдаж, 2006 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Энэ хуульд 2011, 2014, 2020, 2024 онд нэмэлт, өөрчлөлтүүд орсон. Нийт 6 бүлэг, 53 зүйлтэй энэ хууль нь гүтгэлгийн хэргийг шийдвэрлэх, хэвлэл мэдээлэл, цахим орчин дахь гүтгэлгийн зохицуулалтыг тодорхой болгоход чиглэгдсэн.

Тус улсын Эрүүгийн болон Иргэний хуулиар гүтгэх, доромжлохтой холбоотой харилцааг зохицуулдаггүй.

Гүтгэлгийн тухай хууль нь тус улсад гүтгэлгийн нэгдсэн байдлаар зохицуулах үүднээс дараах үндсэн зорилготой. (§1.3) Үүнд:

- үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, ялангуяа нийтийн ашиг сонирхол, чухал асуудлыг нийтлэх, хэлэлцэхэд үндэслэлгүй хязгаарлалт тавихгүй байх;
- гүтгэлгийн шинжтэй зүйл нийтэлж нэр хүнд нь хохирсон этгээдэд үр дүнтэй, шударга арга хэрэгслийг бий болгох;
- гүтгэлгийн шинжтэй зүйлийг нийтэлсэн тухай маргааныг түргэн шуурхай, маргаангүй шийдвэрлэх аргыг дэмжих зэрэг болно.

Хуулийн үйлчлэх хүрээний хувьд, тус улсын бүх муж, нутаг дэвсгэрт үйлчлэх бөгөөд муж, нутаг дэвсгэр бүр өөрийн онцлогт тохируулан нэмэлт журам хэрэгжүүлж болно.

Тус хуулийн зохицуулалтад дараах этгээдүүд хамаардаг. (§9) Үүнд:

[19] Австрали (2005) Defamation Act. Хандах https://www.austlii.edu.au/cgi-bin/viewdb/au/legis/nsw/consol_act/da200599/ Хандсан огноо:2025-03-13.

- хэвлэл мэдээллийн байгууллага (сонин, телевиз, цахим хуудас, олон нийтийн сүлжээ);
- хувь хүн, хуулийн этгээд;
- олон нийтийн сүлжээгээр дамжуулан бусдыг гүтгэсэн хэрэглэгч.

Сонин, сэтгүүл зэрэг тогтмол хэвлэгддэг материалуудыг “тогтмол хэвлэл” (periodical) гэж үзнэ. Мөн цахим мэдээллийн платформууд ч энэхүү ангилалд багтаж болно. (§41(3)).

Хэрэв нийтлэлд тухайн этгээдийн нэрийг тодорхой заасан бол уг нийтлэлийг тухайн этгээд гаргасан гэж үзнэ. Хэрэв хэвлэлийн эзэн, редактор, эсхүл байгууллагын нэр заасан бол уг байгууллага нийтлэлийн хариуцлагыг хүлээнэ (§42).

Гүтгэх (defamation) гэж хүний нэр хүндийг гутаах, буруу ойлголт төрүүлэх, нийгэмд нэр хүндийг нь унагаах зорилготой мэдээ түгээх үйлдлийг хэлнэ. Гүтгэлэг нь бичгээр (libel), эсхүл амаар (slander) үйлдэгдсэн байж болох бөгөөд энэ хоёр нь ижил зохицуулалттай. Хэн нэгэн гуравдагч этгээдэд худал, нэр хүндэд халдсан мэдээлэл түгээх, уг мэдээлэл нь тухайн хүний ажил, амьдралд сөрөг нөлөө үзүүлсэн байх нөхцөлийг шаарддаг (§10B).

Тус хуульд 2020 онд нэмэлт, өөрчлөлт оруулж "ноцтой хор хохирол" (serious harm) гэсэн шалгуурыг (§10A) тусгасан. Үүний дараа хуульд оруулсан 2024 оны нэмэлт, өөрчлөлтөөр “ноцтой хор хохирол” гэдгийг "бодитой бөгөөд мэдэгдэхүйц" (actual and substantial) хохирол гэж нарийвчлан тодорхойлсон (§10A(2)).

Дараах үндсэн шалгуураар гүтгэлгийн хэрэг үүсгэнэ. (§10A) Үүнд:

- нэхэмжлэгчийн нэр хүндэд "ноцтой хор хохирол" учирсан байх (бодит болон боломжит хохирол), эсхүл цаашид учруулах магадлал ихтэй гэдгийг нэмж нотлох шаардлагатай;
- "ноцтой хор хохирол" нь мэргэжлийн нэр хүнд, эдийн засаг, нийгмийн байр сууринд сөргөөр нөлөөлсөн байх. Тухайн хүний нэр хүндэд энгийн бус, мэдэгдэхүйц хэмжээнд сөргөөр нөлөөлж, ажил мэргэжлийн нэр хүнд, эдийн засгийн нөхцөл байдал, нийгмийн байр суурь, эсхүл бусад чухал ашиг сонирхолд бодитойгоор хөнөөл учруулсан байх, эсхүл учруулах өндөр магадлал бүхий хор хохирол байх.

Хуульд “цахим зуучлагч” (digital intermediaries) гэсэн тусгай зохицуулалтыг 2024 оны нэмэлт, өөрчлөлтөөр шинээр нэмсэн. Энэ нь нууцлах үйлчилгээ (caching service), дамжуулах үйлчилгээ (conduit service), хадгалалтын үйлчилгээ (storage service) үзүүлэгчийн талаар зохицуулсан. Түүнчлэн цахим зуучлагчийг хариуцлагаас чөлөөлөх нөхцөлийг тусгасан байна. Тухайлбал, хайлтын системийн үйлчилгээ үзүүлэгч нь дараах тохиолдолд гүтгэлгийн мэдээлэл нийтэлсэнд хариуцлага хүлээхгүй бөгөөд тухайн мэдээллийг гүтгэлэг болохыг мэдсэн, эсхүл мэдэх үндэслэл байсан эсэхээс үл хамаарна (§10E). Үүнд:

- хайлтын үр дүнгийн мэдээллийг автомат процессоор хэрэглэгчдэд хүргэсэн бөгөөд үүнээс өөр оролцоогүй бол;
- хайлтын үр дүнгээс олгосон холбоос бүхий мэдээллийг нийтлэхэд үйлчилгээ үзүүлэгч нь дээр дурдснаас өөр оролцоогүй бол.

Цахим зуучлагчдын хариуцлагаас чөлөөлөх асуудлыг шүүхээс шуурхай шийдвэрлэх бөгөөд шүүх нотлох баримт шаардлагагүй гэж үзвэл талуудын өгсөн нэхэмжлэл, тайлбарт үндэслэн шүүх шийдвэрлэнэ. (§10E). Харин хайлтын үр дүн, эсхүл холбоосыг гуравдагч этгээдээс төлбөртэй буюу бусад ашиг хүртсэний төлөө сурталчилсан, эсхүл нүүр хэсэгт байршуулсан бол хариуцлагаас чөлөөлөгдөхгүй (§10D).

Иргэний маргааныг шүүхийн бус аргаар шийдвэрлэх механизмын (resolution of civil disputes without litigation) талаар хуулийн 3 дугаар бүлэгт зохицуулсан. Үүнд гомдол гаргах (concerns notices), санал болгох (…offers to make amends), уучлал гуйх (apology) зэрэг асуудлыг хамруулсан. Тухайлбал, хэрэв тараасан мэдээлэл нь үнэн бол тухайн этгээдийг гүтгэлэг үйлдсэн гэж үзэхгүй. Мөн төрийн өндөр албан тушаалтны талаарх үнэн бодит мэдээлэл нь олон нийтийн ашиг сонирхолд нийцэж байвал гүтгэлэг гэж үзэхгүй. Гүтгэлгийн мэдээлэл тараасан этгээд алдаагаа хүлээн зөвшөөрч, албан ёсоор уучлал хүссэн бол хохирол барагдуулах хэмжээг бууруулахад харгалзан үзнэ. (§20)

Хуулийн 4 дүгээр бүлэгт иргэний маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны (litigation of civil disputes) талаар зохицуулдаг. Тухайлбал, дараах тохиолдолд тангарагтны шүүх гүтгэлгийн хэргийг хэлэлцэнэ (§21(1)). Үүнд:

- "ноцтой хор хохирол" учирсан эсэх нь маргаантай бол;
- олон нийтийн ашиг сонирхолтой холбоотой маргаан байгаа бол;
- нэхэмжлэгч болон хариуцагч талуудын дунд ихээхэн маргаан үүссэн бол.

Гүтгэлгийн тухай хуулиар нэг гүтгэлгийн мэдээлэлд хэрэг үүсгэсэн бол энэ асуудлаар өөр шүүхэд нэхэмжлэл гаргах боломжгүй. Шаардлагатай бол зөвхөн шүүхийн зөвшөөрлөөр дахин хэрэг үүсгэж болохоор зохицуулсан (§4(2.24)) нь нэг мэдээлэлд олон удаа нэхэмжлэл гаргах явдлыг хязгаарласан байна.

Хэрэв сэтгүүлч, судлаач зэрэг хүмүүс олон нийтийн ашиг сонирхолтой холбоотой мэдээлэл нийтэлсэн бол гүтгэлгийн хэрэг үүсгэхээс зайлсхийх хамгаалалтын механизмуудыг (defence mechanisms) хуулиар зохицуулдаг. Дараах тохиолдолд хариуцлага хүлээхгүй. (§25) Үүнд:

- үнэн мэдээлэл (truth defence) – хэрэв нийтлэгдсэн мэдээлэл үнэн бол (§26);
- шударга санал бодол (honest opinion defence) – үзэл бодлоо илэрхийлсэн бол, хэрэв тухайн мэдээлэл баримтад үндэслэсэн бол (§31);
- олон нийтийн ашиг сонирхол (public interest defence) – хэрэв мэдээлэл олон нийтийн ашиг сонирхолд нийцсэн бол (§29A).

Мөн абсолют эрхийн хамгаалалт (defence of absolute privilege) гэж тухайн мэдээллийг нийтлэх үед ямар ч тохиолдолд гүтгэлгийн хэрэг үүсгэх боломжгүй нөхцөлийг хэлнэ. Тухайлбал, шүүх хурал, шүүхийн шийдвэр, гэрчийн мэдүүлэг, албан ёсны бичиг баримт, мэдээлэл болон олон нийтэд зориулсан албан ёсны бичиг баримтад багтсан бол тухайн мэдээллийг нийтлэгч нь энэхүү хамгаалалтад хамаарахаар заасан. (§27)

Хохирол нөхөн төлүүлэх арга хэмжээний талаар зохицуулсан. Гүтгэлгийн маргаантай холбоотой хэрэгт хохирогч этгээдэд олгох нөхөн төлбөрийн (remedies) хэмжээ нь хохирлын бодит байдлаас хамаарна. Хэрэв гүтгэлэг гаргасан хүн уучлалт гуйсан, залруулсан, эсхүл хохирогч өөр газраас нөхөн төлбөр авсан нь төлбөрийн хэмжээг бууруулах үндэслэл болно. (§40)

Хэрэв шүүх гүтгэлгийн хэргийг хэлэлцээд нэгээс олон үндэслэлээр (олон төрлийн мэдээлэл эсхүл хэд хэдэн өөр мэдээлэл нийтэлсний улмаас) хохирогчийн талд шийдвэр гаргасан бол эдгээр бүх үндэслэлээр учирсан хохирлыг нэгтгэн нэг нийт дүнгээр тооцож нөхөн төлбөрийг тогтоож болно (§40(2)).

2.3.2.Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс

А) ГҮТГЭЛГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс (ИБУИНХУ)-ын Гүтгэлгийн тухай хууль[20] нь 2013 онд шинэчлэн батлагдаж, 2014 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон. Тус хууль нь 17 зүйлтэй бөгөөд гүтгэлгийн асуудлыг иргэний эрх зүйн хүрээнд зохицуулдаг.

Гүтгэлгийн тухай хууль нь тус улсын шүүн таслах практикийн үндсэн дээр хөгжиж ирсэн нийтийн эрх зүйн (common law) зарчмуудыг тодорхой болгож, 1952 болон 1996 оны Гүтгэлгийн тухай хуулиудын дээр суурилан шинэчлэгдсэн (Government, 2013).

Хуулийн үйлчлэх хүрээний хувьд Англи, Уэльст үйлчилнэ. (§17(3)) Харин Шотланд, Хойд Ирландад тусдаа хууль тогтоомж мөрдөнө. (Government, 2013)

Гүтгэлгийн нэхэмжлэлийг хувь хүн болон хуулийн этгээд гаргах боломжтой боловч бүртгэлгүй байгууллага болон Засгийн газрын байгууллага энэ төрлийн нэхэмжлэл гаргахгүй (Gowling WLG, 2024).

Гүтгэх (defamation) нь гуравдагч этгээдэд чиглэсэн мэдээлэл нийтлэгдсэнээр хэн нэгний талаар сөрөг ойлголт төрүүлж, нэр хүндэд нь ноцтой хохирол учруулах буюу учруулж болзошгүй нөхцөл байдлыг бий болгохыг хэлэх бөгөөд дараах хоёр хэлбэртэй байна (Gowling WLG, 2024):

- бичгээр үйлдэгдсэн (libel) – нийтлэл, цахим шуудан, нийгмийн сүлжээний пост гэх мэт бичгээр дамжуулсан мэдээлэл;
- амаар үйлдэгдсэн (slander) – ярианы хэлбэрээр бусдад тараагдсан мэдээлэл.

Бичгээр болон амаар үйлдэгдсэн гүтгэлгийн ялгаатай талууд

Бичгээр үйлдэгдсэн гүтгэлэг (libel)	***Амаар үйлдэгдсэн гүтгэлэг (slander)***
Байнгын хэлбэрээр үлдсэн мэдээлэл, тухайлбал, шог зураг, театрын жүжиг, кино, телевиз, радио нэвтрүүлэг.	Түр зуурын, бичгээр үлдээгүй мэдээлэл, тухайлбал, аман яриа, дохио зангаа.
Нийтлэгдсэн болохыг нотлох шаардлагатай боловч "ноцтой хохирол" шалгуурыг давсан байх ёстой.	Нийтлэгдсэн болохыг нотлоход илүү хүндрэлтэй, учир нь мэдээлэл нь байнгын хэлбэртэй үлдээгүй байдаг. "Ноцтой хохирол" шалгуур мөн үйлчилнэ.
Нэр хүндийн хохирлын ерөнхий нөхөн төлбөр шаардах боломжтой.	Тусгай хохирол (шууд учирсан санхүүгийн хохирол) нотлогдсон тохиолдолд нэхэмжлэл гаргах боломжтой. Хэрэв тусгай хохирлын нотолгоо байхгүй бол дараах нөхцөлд нэхэмжлэл гаргах боломжтой: • ашигласан үг нь гэмт хэргийн шинжтэй бол; • ашигласан үг нь тухайн хүн ажил албан тушаал, мэргэжил, эрхэлж буй

[20] ИБУИНХУ (2013) [2020]. Defamation Act 2013. Хандах: https://www.legislation.gov.uk/ukpga/2013/26/enacted Хандсан огноо: 2025-03-06.

	үйл ажиллагаандаа хохирол амсах нөхцөл бүрдүүлсэн бол.

Эх сурвалж: (Gowling WLG, 2024).

Гүтгэлгийн тухай хуулийн 1(1)-т заасны дагуу “учруулж болзошгүй нөхцөл байдал” гэдэг нь гүтгэлгийн нэхэмжлэл гаргах үед хохирол хараахан үүсээгүй байсан ч, ирээдүйд ноцтой хохирол учрах бодит эрсдэл байгааг хамардаг (Government, 2013).

Ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдийн хувьд, нэр хүндэд нь учирсан хохирол нь ноцтой санхүүгийн алдагдал учруулсан буюу учруулах бодит эрсдэлтэй гэж нотлогдсон тохиолдолд л **"ноцтой хохирол"** (serious harm) гэж тооцно. (§1(2))

Шүүхээс "ноцтой хохирол" гэсэн шалгуурыг дараах хүчин зүйлээр тодорхойлно (Gowling WLG, 2024):

- гүтгэлгийн утга, агуулга;
- хэдэн хүнд, хэр өргөн хүрээнд түгсэн байдал;
- нийтлэлийг ямар хүмүүс үзсэн, эсхүл хандах боломжтой байсан эсэх;
- хохирогчийн нэр хүнд хэрхэн өөрчлөгдсөн.

Шүүхийн практикт, "ноцтой байдлын босго" (serious harm threshold) шаардсанаар ач холбогдолгүй, ашиг сонирхлын бага зөрчилтэй хэргийг шүүхэд гаргахаас сэргийлдэг. Ашгийн төлөө байгууллага сэтгэл санааны хохирол нэхэмжлэх боломжгүй бөгөөд зөвхөн ноцтой санхүүгийн хохирлыг шаарддаг (Government, 2013).

Хуульд гүтгэлгийн эсрэг дараах **хамгаалалтын механизмууд** байдаг. Үүнд:

- үнэн бодит баримт (truth) – тухайн мэдээлэл үнэн бөгөөд нотлогдсон бол гүтгэлэг гэж үзэхгүй (§2);
- шударга санал бодол (honest opinion) – тухайн мэдэгдэл нь субьектив санаа бодол байсан бол хариуцлага хүлээлгэхгүй (§3). Үүний тулд дараах гурван нөхцөлийг хангах шаардлагатай (Government, 2013):

  1) мэдэгдэл нь санаа бодол байх;
  2) санаа бодлын үндэслэл тодорхой илэрхийлэгдсэн байх;
  3) шударга хүн тухайн үед оршин байсан баримтад тулгуурлан ийм санаа бодол гаргах боломжтой байх;

- олон нийтийн ашиг сонирхол (public interest) – нийтийн ашиг сонирхолд нийцсэн мэдээллийг нийтэлсэн тохиолдолд хамгаалалт болно (§4);
- цахим хуудасны оператор (operators of websites) – цахим хуудасны оператор нь тухайн мэдээллийг өөрөө нийтлээгүй, харин хэрэглэгч байршуулсан бол тодорхой нөхцөлд хариуцлагаас чөлөөлөгдөнө. Гомдол ирсэн тохиолдолд устгах арга хэмжээ авах үүрэгтэй (§5);
- шинжлэх ухааны судалгааны өгүүлэл (peer-reviewed statement) – хянан магадалсан эрдэм шинжилгээний сэтгүүлд нийтлэгдсэн өгүүлэл гүтгэлгийн нэхэмжлэлээс хамгаалагдана (§6);
- хууль ёсны дархан эрх (absolute and qualified privilege) – Парламентын болон шүүхийн баримт бичиг зэрэг эх сурвалжаас авсан мэдээлэлд хариуцлага хүлээлгэхгүй (§7).

Хуулиар **нэг удаагийн нийтлэлийн дүрэм** (single publication rule)-ийг зохицуулдаг. Энэ нь анх нийтлэгдсэн өдрөөс хойш нэг жилийн дотор гүтгэлгийн нэхэмжлэл гаргаагүй тохиолдолд, тухайн материалыг дахин нийтэлсний үндсэн дээр ижил нийтлэгчийн эсрэг шинэ нэхэмжлэл гаргах боломжгүй (§8). Энэ нь өмнө нь мөрдөгдөж байсан, гүтгэлгийн шинжтэй материал бүрийн дахин нийтлэл нь тусдаа хариуцлага хүлээх үндэслэл болдог зарчмыг халж байгаа юм.

Энэхүү зохицуулалт нь хэвлэлийн орчин үеийн онцлогийг тусгасан бөгөөд цахим орчинд тухайн материал татаж авах бүр нь шинэ нийтлэлд тооцож, олон удаа хариуцлага үүсэхээс сэргийлэх зорилготой (Dawson, 2014).

Б) ИРГЭНИЙ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ДҮРМИЙН ЗОХИЦУУЛАЛТ

ИБУИНХУ-ын Гүтгэлгийн тухай хууль нь иргэний эрх зүйн хүрээнд үйлчилдэг. Тус улсад нэгдсэн Иргэний хууль байдаггүй бөгөөд иргэний эрх зүй нь Парламентаас баталсан хууль, шүүхийн шийдвэрийн үндсэн дээр хөгжиж ирсэн (Lovells, 2016, хууд. 1). Иймд Гүтгэлгийн тухай хууль нь Иргэний хэрэг хянан шийдвэрлэх дүрэм, нийтийн эрх зүй (common law) болон бусад холбогдох хууль тогтоомжуудтай уялдан хэрэгждэг.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн[21] 53 дугаар хэсэг нь “Хэвлэл мэдээлэл ба харилцааны нэхэмжлэлүүд” (Media and Communications Claims)-ийг тусгайлан зохицуулж, гүтгэлгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны процесс, нотлох баримтыг гаргах хугацаа, шүүхийн хялбаршуулсан журмаар шийдвэрлэх, мэдээллийн эрх чөлөөний асуудлуудыг зохицуулдаг.

Гүтгэлгийн тухай хуулийн дагуу хувь хүн, эсхүл байгууллагын нэр төрд халдсан гэж үзсэн мэдээлэлтэй холбоотой маргааныг шүүх хянан шийдвэрлэхдээ Иргэний хэрэг хянан шийдвэрлэх дүрмийг баримтална. (§53.1)

Гүтгэлгийн хэрэг нь “Хэвлэл мэдээлэл, харилцааны жагсаалт” (Media and Communications List)-д бүртгэгдэх бөгөөд харьяалал нь Дээд шүүхийн Хааны танхимын шүүх (King’s Bench Division)[22]-д хамаардаг. (§53.2)

Гүтгэлгийн хэрэг хянан шийдвэрлэх явцад талууд шүүхийн тогтоосон хугацаанд нотлох баримт гаргах, солилцох үүрэгтэй бөгөөд уг хугацааг мөрдөөгүй тохиолдолд шүүх тухайн баримтыг хүлээн авахаас татгалзах, эсхүл хэргийг талуудын эсрэг шийдвэрлэх зэрэг арга хэмжээ авч болно. Нотлох баримт гаргах шаардлага нь Гүтгэлгийн тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасан "ноцтой хохирол" шалгуурыг хангаж буй эсэхийг нотлох үндэслэл болох юм. (§53.3)

Гүтгэлгийн хэрэг **хялбаршуулсан журмаар шийдвэрлэх** (summary disposal) нь шүүхээс маргааныг шуурхай шийдвэрлэх боломжийг олгодог механизм юм. Хэрэв нэхэмжлэл нь "ноцтой хохирол" (serious harm) шалгуурыг хангахгүй гэж шүүх үзвэл, эсхүл хариуцагч нь хамгаалалтын механизмд хамаарахаа хангалттай нотолсон бол нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох, эсхүл хязгаарласан нөхцөлөөр шийдвэрлэх боломжтой.

---

[21] ИБУИНХУ (1998) [2025]. Civil Procedure Rules 1998. Хандах: https://www.legislation.gov.uk/uksi/1998/3132/contents. Хандсан огноо: 2025-03-06.

[22] Хааны танхимын шүүх (King's Bench Division) нь Англи, Уэльсийн Дээд шүүхийн (High Court of Justice) гурван үндсэн танхимын нэг бөгөөд иргэний болон эрүүгийн өргөн хүрээний хэргийн харьяалалтай хэрэг хянан шийдвэрлэдэг танхим юм. Энэхүү танхим нь гэрээний маргаан, гэм хорын нэхэмжлэл, гүтгэлэг, хувийн гэмтэл, хуулийн хяналт зэрэг нийтийн эрх зүйн хэргүүдийг хянан шийдвэрлэхээс гадна, тодорхой доод шатны шүүхүүдэд хяналтын үүрэг гүйцэтгэдэг. Эх сурвалж: Judiciary of England and Wales. *King’s Bench Division.* Хандах линк: https://www.judiciary.uk/courts-and-tribunals/kings-bench-division/work-3/ Хандсан огноо: 2025-03-13.

Энэхүү зохицуулалт нь Гүтгэлгийн тухай хуулийн зорилготой нийцэж, маргааныг сунжрахгүйгээр шуурхай шийдвэрлэх, шүүхийн ачааллыг бууруулахад чиглэгддэг. (§53.5)

Гүтгэлгийн хэрэг хянан шийдвэрлэх явцад хэвлэл мэдээллийн байгууллагуудын **мэдээллийн эх сурвалжийг хамгаалах** зохицуулалт үйлчилнэ. Шүүх зөвхөн онцгой нөхцөлд л мэдээллийн эх сурвалжийг ил болгох үүрэг өгч эрхтэй. (§53.6)

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Энэхүү судалгаагаар гүтгэх (defamation), доромжлох (insult), худал мэдээлэл тараахтай холбоотой гэмт хэрэг (Монгол Улсын Зөрчлийн хуулиар зөрчил)-ийн зохицуулалтыг Монгол Улс болон гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалтын хүрээнд авч үзсэн бөгөөд эдгээр улсуудад гүтгэх болон доромжлох гэсэн нэр томьёог нийтлэг ашиглаж байна.

Нэр томьёоны хувьд, “Гүтгэх” гэдэг нь хувь хүн, байгууллага, эсхүл албан тушаалтны нэр төр, нэр хүндэд халдаж, тэдний талаар үндэслэлгүй, худал мэдээлэл тарааснаар нэр хүндийг нь гутаах үйлдлийг ойлгоно. Харин “доромжлох” гэдэг нь хууль зүйн хувьд нийтээр тогтсон ёс суртахуун, зан үйлийн хэм хэмжээг үл хүндэтгэн, тухайн хүнийг гутаах, доог тохуу болгох зорилгоор сөргөөр буюу зүй бус, зохисгүй байдлаар нэрлэх, үнэлэх, хүний зан үйл, зан төлөвийн үнэн бодит байдал, хүний алдар хүндэтгэлийг гуйвуулан үгүйсгэж буй явдал юм (ННФ, Х3 мэдээлэл, судлгааны хамтын ажиллагааны нийгэмлэг, 2021, p. 42).

Судалгаанд хамрагдсан Герман (доромжлох, худал цуу яриа тараах, гүтгэх), Польш (гүтгэх, доромжлох), Унгар (гүтгэх, аман гүтгэлэг, гутаах), Болгар (доромжлох, гүтгэх, хууль бусаар олж авсан мэдээлэл тараах), Солонгос (гүтгэх, нийтлэлээр гүтгэх, доромжлох), Швед (гүтгэх), Австрали (гүтгэх), ИБУИНХУ (гүтгэх) зэрэг улсуудад нийтлэг байдлаар “гүтгэх” болон “доромжлох” гэсэн нэр томьёог хэрэглэдэг байна.

“Амаар гүтгэх” (slander) болон “бичгээр гүтгэх” (libel) нь “гүтгэх” гэсэн агуулгад багтаж байна. Тухайлбал, Австрали Улс 2024 онд Гүтгэлгийн тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр амаар болон бичгээр гүтгэх үйлдлийг ялгаж авч үзэхээ больж, нэг зохицуулалтаар зохицуулдаг болжээ.

Харин Монгол Улсын хувьд худал мэдээлэл тараах, гүтгэх гэсэн нэр томьёог хэрэглэж байна. Тодруулбал, Эрүүгийн хуулиар “худал мэдээлэл тараах” гэмт хэрэг, Зөрчлийн тухай хуулиар “гүтгэх” зөрчил, Иргэний хуулиар “иргэний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан” этгээдэд гэм хорыг арилгахтай холбоотой харилцааг тус тус зохицуулж байна.

Судалгаанд хамрагдсан улсуудын эрх зүйн зохицуулалтаас үзэхэд, гүтгэх, доромжлох гэмт хэргийг эрүүгийн болон иргэний хуулиар зохицуулдаг (Герман, Польш, Унгар), эрүүгийн болон салбар, бусад хуулиар зохицуулдаг (Болгар, Солонгос, Швед) болон бие даасан хуулиар зохицуулдаг (Австрали, ИБУИНХУ) гэсэн гурван хэлбэр/чиг хандлага байна.

1) Эрүүгийн болон иргэний хуулиар зохицуулдаг улс орнууд:

Герман, Польш, Унгар зэрэг улс нь гүтгэх, доромжлох, нэр төрийг хамгаалахдаа эрүүгийн болон иргэний хуулийн хосолсон зохицуулалтаар зохицуулдаг. Эрүүгийн хуулиар гүтгэх, доромжлох үйлдэлд нэгээс таван жил хүртэл хорих ял, торгууль оногдуулах бөгөөд дараах нөхцөлд ял шийтгэлийг хүндрүүлнэ. Үүнд:

Герман – улс төрийн үйл ажиллагаа эрхэлдэг этгээдийг онцгойлон хамгаалдаг;

Польш Улс – хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан үйлдсэн тохиолдлыг хүндрүүлэх нөхцөл гэж үздэг;

Унгар Улс – олон нийтийн өмнө үйлдсэн үйлдлийг хүндрүүлэх нөхцөлд тооцдог.

Харин Иргэний хуулийн зохицуулалтын хүрээнд хувь хүний нэр төр, алдар хүнд, хувийн эрх чөлөө болон хувийн мэдээллийг хамгаалах нийтлэг зарчмыг баримталдаг. Герман Улсын Иргэний хууль нь санхүүгийн нэр хүнд, зээлийн эрсдэлийг хамгаалдаг нь

бусад орнуудаас ялгарах онцлогтой байна. Польш Улс хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг давхар онцолж, нэр төр, хувийн нууцыг хамгаалахыг чухалчилдаг. Унгар Улс нь хувийн мэдээлэл, зураг, дүрс бичлэг, дуу хоолой зэрэг хувь хүний амьдрал, нэр хүндтэй холбоотой илүү олон элементүүдийг тусгайлан авч үзэж хамгаалдаг байна.

2) Эрүүгийн болон салбар, бусад хуулиар зохицуулдаг улс орнууд:

Болгар, Солонгос, Швед улсад гүтгэх, доромжлох үйлдлийг эрүүгийн болон хэвлэл мэдээллийн салбарын болон бусад хуулиудаар давхар зохицуулж байна. Эрүүгийн хуулиар гүтгэх, доромжлох үйлдэлд торгууль болон зургаан сараас долоон жил хүртэл хорих ял оногдуулах бөгөөд дараах нөхцөлд ял шийтгэлийг хүндрүүлнэ. Үүнд:

Болгар Улс – хэвлэл мэдээллээр тараасан гүтгэлгийг хүндрүүлэх нөхцөл гэж үздэг;

Солонгос Улс – худал мэдээлэл тараасан тохиолдолд хамгийн хүнд ял (7 жил хүртэл хорих ял) ногдуулдаг;

Швед Улс – гүтгэлгийг ноцтой байдлаас нь хамаарч торгууль, 6 сар хүртэл хорих ял оноодог.

Харин Хэвлэл мэдээллийн хуулиар мэдээллийн үнэн зөв байдал, нийтийн ашиг сонирхлыг харгалзан ял шийтгэл оногдуулах эсэхийг шийдвэрлэх онцлогтой. Тодруулбал:

Болгар Улс – хувийн мэдээллийг хамгаалдаг ч нийтийн ашиг сонирхолтой холбоотой мэдээлэлд хариуцлагаас чөлөөлдөг;

Солонгос Улс – хэвлэл мэдээллийн байгууллага, хувь сэтгүүлчийн хариуцлагыг ялгаж, нэр төрд халдсан тохиолдолд нөхөн төлбөр олгох, нэр хүнд сэргээх механизмыг хуульчилсан;

Швед Улс – хэвлэлийн эрх чөлөөг хамгаалдаг ч, гүтгэлгийн асуудлыг ихэвчлэн хохирогчийн гомдлыг дагуу авч шийдвэрлэдэг.

3) Бие даасан гүтгэлгийн хуулиар зохицуулдаг улс орнууд

Австрали, ИБУИНХУ-д гүтгэх, доромжлохтой холбоотой харилцааг бие даасан Гүтгэлгийн тухай хууль (Defamation Act)-иар зохицуулдаг. Бие даасан хуулийн онцлог нь нэгд – иргэний хэрэг хянан шийдвэрлэх журмаар зохицуулагддаг, хоёрт – нэхэмжлэл гаргах журам, хамгаалалтын механизм нь тодорхой, гуравт – үнэн зөв мэдээлэл, шударга санаа бодол, олон нийтийн ашиг сонирхол зэргийг хамгаалалтын үндэслэл болгодог байна.

Хоёр улсын бие даасан хуулиудад цахим орчинд нийтлэгдсэн гүтгэлгийн шинжтэй контентыг зохицуулдаг: Австрали Улс 2024 онд Гүтгэлгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, цахим зуучлагчдын (search engine, платформ)-д хамаарах этгээдийн хариуцлагаас чөлөөлөх, гүтгэлгийн шинжтэй контентыг устгах журмыг нэмж оруулжээ. ИБУИНХУ "нэг удаагийн нийтлэл" зарчим баримталж, цахим хуудасны операторуудын хариуцлагыг тогтоон, гүтгэлгийн хэргийн хамгаалалтын үндэслэлийг хуульчилдаг.

Мөн хуулиар гүтгэлгийн маргааныг шүүхийн бус аргаар шийдвэрлэх механизмыг зохицуулдаг. Тухайлбал, ИБУИНХУ-д гүтгэлгийн хэргийг "хялбаршуулсан журам"-аар шуурхай шийдвэрлэх боломжтой, Австрали Улсад шүүхээс гадуур гомдол гаргах, уучлал хүсэх зэрэг арга хэмжээг авахаар зохицуулсан байна.

Ашигласан материал

Д.Оросоо. (2021). Худал мэдээлэл тараах гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй практик-илт худал мэдээлэл гэх ойлголтын эрүүгийн эрх зүйн асуудал. Улаанбаатар: Нээлттэй нийгэм форум.

ПСХХ. (2024). Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах, хэвлэн нийтлэх эрх, эрх чөлөөний талаарх олон улсын хэм хэмжээ ба гадаадын зарим орны туршлага. Улаанбаатар хот.

Dawson, J. (2014, January 21). Retrieved from The Defamation Act 2013: https://researchbriefings.files.parliament.uk/documents/SN06801/SN06801.pdf

Government, U. (2013). Retrieved from Defamation Act 2013: Explanatory Notes: https://www.legislation.gov.uk/ukpga/2013/26/notes/division/2

Gowling WLG. (2024, April 15). The Libel Bible: The basics of defamation law. Retrieved from LEXOLOGY PRO: https://www.lexology.com/library/detail.aspx?g=fdb7049d-878c-4a21-823a-7e846fe8da17

Lovells, H. (2016). Retrieved from Introduction to civil proceedings in England and Wales: https://www.hoganlovells.com/~/media/hogan-lovells/pdf/news/2016/3494590v2client-note-introduction-to-civil-proceedings-in-england-approved-versionlwdlib02.pdf